# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 36 (561)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Улсын Их Хурлын 2008 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Дамбадондогийн Баатаржавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Үндэсний хөтөлбөр батлах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2008 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот | 2008 оны есдүгээр сарын 28 | №36 (561)

## Гарчиг


### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 624. | Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай | Дугаар 20 | 1025 |
| 625. | Д.Сандаг-Очирыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 21 | 1026 |
| 626. | Улсын Их Хурлын 2008 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай | Дугаар 22 | 1026 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 627. | Ричард Маккензи-г "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 274 | 1027 |
| 628. | Дамбадондогийн Баатаржавт Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай | Дугаар 277 | 1028 |
| 629. | Дамбадондогийн Баатаржавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай | Дугаар 278 | 1028 |
| 630. | Кобаяши Хироюки-г "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 279 | 1028 |
| 631. | Уолтер Женкинсийг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 280 | 1028 |
| 632. | Хон Чин Юй-г "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 281 | 1029 |
| 633. | ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 282 | 1029 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 634. | Журам батлах тухай | Дугаар 305 | 1029 |
| 635. | Үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 316 | 1035 |
| 636. | Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай | Дугаар 338 | 1048 |


## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр** | **Дугаар 20** | **Улаанбаатар хот**

### Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Цэрэнхүүгийн Шаравдоржийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр** — **Дугаар 21** — **Улаанбаатар хот**

**Д.Сандаг-Очирыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Данзангийн Сандаг-Очирыг өөр ажилд томилогдсонтой нь холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр** — **Дугаар 22** — **Улаанбаатар хот**

**Улсын Их Хурлын 2008 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2008 оны намрын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/ "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

2/ Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

3/ Монгол Улсын 2007 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2007 оны санхүүгийн нэгдсэн тайлан;

4/ Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуулийн төсөл;

5/ Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуулийн төсөл;

6/ Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуулийн төсөл;

7/ "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

8/ "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

9/ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

10/ Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл /гурилыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн хугацааг сунгах/;

11/ Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

12/ Монгол Улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө зарцуулах тухай хуулийн төсөл /ноолуурын урьдчилгаанд шаардагдах хөрөнгө гаргах тухай/, "Тогтоолын зарим заалтыг хүчингүй болгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

13/ Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

14/ "Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

15/ Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн төсөл;

16/ Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн төсөл;

17/ Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

18/ Агаарын төлбөрийн тухай хуулийн төсөл;

19/ Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

20/ Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тухай хуулийн төсөл /Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга/, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

21/ Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

22/ Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл;

23/ "Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

24/ Бусад.

2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, мөн энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг 2008 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухайн үед нь шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр энэ тогтоолд дурдаагүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчдаас өргөн мэдүүлбэл энэ оны намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

4.Улсын Их Хурлын 2008 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Засгийн газар, Байнгын хороодын дарга, Улсын Их Хурал дахь намын бүлгийн ахлагч нар болон Тамгын газар /Ц.Шаравдорж/-т тус тус даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр** | **Дугаар 274** | **Улаанбаатар хот**

### Ричард Маккензи-г "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, АНУ-ын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх болон манай улсын эрүүл мэндийн салбарт оруулсан хувь нэмрийг нь үнэлж АНУ-ын Калифорни мужийн Өмнөд Калифорнийн их сургуулийн доктор, профессор Ричард Маккензи-г "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр** — **Дугаар 277** — **Улаанбаатар хот**

**Дамбадондогийн Баатаржавт Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай**

Бээжин хотноо болсон паралимпийн XIII их наадмын байт харвааны төрөлд амжилттай оролцож алтан медаль хүртсэн, Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын наадмын алт, мөнгө, хүрэл медальт, байт харвааны олон улсын хэмжээний мастер Дамбадондогийн Баатаржавт Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр** — **Дугаар 278** — **Улаанбаатар хот**

**Дамбадондогийн Баатаржавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай**

2000 оны Сиднейн паралимп, 2004 оны Афины паралимпийн наадмын шагналт байруудад шалгарч, Ази, Номхойн далайн бүс нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын наадмын алт, мөнгө, хүрэл медаль, 2008 оны Бээжингийн XIII паралимпийн их наадмын байт харвааны төрөлд гарамгай амжилт гарган анхны алтан медалийн эзэн болж, паралимпийн аварга хэмээх эрхэм дээд алдрыг хүртсэн, олон улсын хэмжээний мастер Дамбадондогийн Баатаржавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр** — **Дугаар 279** — **Улаанбаатар хот**

**Кобаяши Хироюки-г "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улс, Япон Улсын иж бүрэн түншлэлийн харилцааг шинэ шатанд гарган хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Элчин зөвлөх Кобаяши Хироюки-г "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр** — **Дугаар 280** — **Улаанбаатар хот**

**Уолтер Женкинсийг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улс, АНУ-ын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, монголын залуучуудын улс төрийн боловсролыг дээшлүүлэх болон манай орны соёл урлагийг АНУ-д сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж АНУ дахь Зориг сангийн Удирдах зөвлөлийн дарга Уолтер Женкинсийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр | Дугаар 281 | Улаанбаатар хот

### Хон Чин Юй-г "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Тайваний соёл урлагийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Тайваний яруу найрагч, Дэлхийн урлаг соёлын академийн доктор Хон Чин Юй-г "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр | Дугаар 282 | Улаанбаатар хот

### ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улсад уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын иргэн дараахь хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Виктор Анатольевич Тюрин - "Монголросцветмет" ХХК-ийн ерөнхий захирлын нэгдүгээр орлогч

**"НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР:**

1. Владимир Карпович Иванов - "Монголросцветмет" ХХК-ийн харьяа Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэрийн ерөнхий механик

2. Сергей Пантелеевич Бабешко - "Монголросцветмет" ХХК-ийн харьяа Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн бэхэлгээчин

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 07 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 305 | Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.2.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулах, хорио цээр, хязгаарлалтын бүс тогтоох, уг бүсэд үйл ажиллагаа явуулах журам"-ыг хавсралтын ёсоор батласугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Ц.ГАНХУЯГ**

Засгийн газрын 2008 оны 305 дугаар тогтоолын хавсралт

### МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ОНОШИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ХОРИО ЦЭЭР, ХЯЗГААРЛАЛТЫН БҮС ТОГТООХ, УГ БҮСЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журам нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны гоц халдварт өвчний сэжиг илэрсэн үед түүний оношийг баталгаажуулах, өвчин гарсан үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн бүс тогтоох, уг бүсэд үйл ажиллагаа явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагын "Хуурай газрын амьтны эрүүл мэндийн код"-д заасан гоц халдварт өвчний сэжиг илрэх үед өвчний эпизоотологийн судалгаа, эмнэл зүй, эмгэг хувиралт болон лабораторийн шинжилгээний аргаар оношийг тогтооно.

3. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15.1.1-д заасан гоц халдварт өвчин, Монгол Улсын нутаг дэвсгэрт урьд өмнө нь гарч байгаагүй, нийгэм, эдийн засагт их хэмжээний хохирол учруулахуйц өвчин болон онош, үүсгэгч нь тодорхойгүй өвчний оношийг албан ёсоор баталгаажуулна.

4. Мал, амьтны гоц халдварт өвчний онош тогтоох ажлыг эрх бүхий байгууллагаар итгэмжлэгдсэн биоаюулгүйн гурав болон дөрөвдүгээр ангиллын зэрэглэлтэй лабораторид хийнэ.

5. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэхүү журмын 4-т заасан лабораторийг тоног төхөөрөмжийн хангамж, эмч, мэргэжилтний чадавхи болон туршлага, биоаюулгүй байдлын зэрэглэлээр нь шалгаруулж тодорхой өвчний оношийг тогтоох, баталгаажуулах үндэсний лавлагаа лабораторийн эрхтэйгээр сонгон ажиллуулж болно.

6. Мал, амьтны гоц халдварт өвчний онош тогтоох, баталгаажуулах ажлыг малын халдварт өвчний илрүүлэх болон баталгаажуулах оношилгооны аргыг эзэмшиж мэргэшсэн малын их эмч хэрэгжүүлнэ.

7. Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан тохиолдолд хорио цээр, хязгаарлалт тогтоох, цуцлах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

8. Хорио цээр, хязгаарлалтын үргэлжлэх хугацааг тухайн гоц халдварт өвчинтэй тэмцэх заавар, мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тогтооно.

9. Энэхүү журмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд дагаж мөрдөх үүрэгтэй.

### Хоёр. Оношилгооны лабораторийн үйл ажиллагааны чиглэл

10. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий лаборатори дараахь үүрэг хүлээнэ:

10.1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15.1.1-д заасан гоц халдварт өвчин, Монгол Улсын нутаг дэвсгэрт урьд өмнө нь гарч байгаагүй, нийгэм, эдийн засагт их хэмжээний хохирол учруулахуйц өвчин болон онош, үүсгэгч нь тодорхойгүй өвчний оношийг тогтоох;

10.2. аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори болон малын өвчний оношилгоо, судалгааны ажил хэрэгжүүлдэг бусад лабораториос ирүүлсэн дээжийг шинжлэн тэдний тавьсан оношийг баталгаажуулах, ялгаварлан оношлох;

10.3. лабораторийн ажилтнуудыг мал, амьтны гоц халдварт өвчнийг оношлох талаар мэргэшил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх;

10.4. малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулах зорилгоор анхны онош тогтоогдсоноос хойш ажлын гурван өдөрт багтаан дэлхийн болон бүс нутгийн лавлагаа лабораторид дээжийг зохих стандартын дагуу илгээх;

10.5. гоц халдварт өвчин оношлогдсон болон батлагдсан талаар хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад цаг тухайд нь мэдээлэх.

11. Малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулах үед дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

11.1. малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулахад шаардагдах дээж авах, хүргэх үйл ажиллагааг холбогдох журам, стандартын дагуу хэрэгжүүлэх;

11.2. малын гоц халдварт өвчнийг оношлох, баталгаажуулах шинжилгээний биоаюултай дээжийг орон нутгийн болон олон улсын тээврийн хэрэгслээр лавлагаа лабораторид илгээхдээ зам,

тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмыг мөрдөх;

11.3. малын гоц халдварт өвчний оношилгоонд Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталсан "Лабораторийн шинжилгээний гарын авлага"-д малын өвчин тус бүрээр заасан "үндсэн", эсхүл түүнийг "орлуулах" аргыг баримтлах;

11.4. өвчнийг оношлох болон баталгаажуулах шинжилгээнд үндэсний болон олон улсын лавлагаа омог, эерэг, сөрөг хяналтын сорьц ашиглах;

11.5. өвчнийг оношлох болон баталгаажуулах шинжилгээнд тухайн шинжилгээний бэлтгэл хангах, шинжлэх, үр дүнг боловсруулах, харьцуулалт, дүгнэлт хийх стандарт хугацааг баримтлах бөгөөд шаардлагатай тохиолдолд шинжилгээг дахин хийх;

11.6. өвчнийг оношлох, баталгаажуулах шинжилгээнд ирүүлсэн дээж шаардлага хангахгүй, эсхүл өвчний үргэлжлэх хугацаанд дээж дахин авах шаардлага гарсан тохиолдолд дээж болон оношилгоонд хэрэгцээтэй нэмэлт мэдээллийг орон нутгийн мал эмнэлгийн байгууллага болон шуурхай бүлгээс шаардаж авах;

11.7. малын гоц халдварт өвчний онош баталгаажуулах асуудлыг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагаас сонгосон дэлхийн болон бүс нутгийн лавлагаа лабораторид дээжийг шинжлүүлж баталгаажуулах;

11.8. шаардлагатай тохиолдолд Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагаас мэргэжилтэн урьж гоц халдварт өвчний эпизоотологийн судалгаа, эмнэл зүй, эмгэг хувиралт болон лабораторийн шинжилгээний хосломол аргаар оношийг баталгаажуулах;

11.9. гоц халдварт өвчний тавьсан онош батлагдаагүй тохиолдолд итгэмжлэл олгосон энэхүү журмын 5-д заасан эрх бүхий байгууллага нь шинжилгээ хийсэн лабораторийн мэргэжилтний шинжилгээний арга зүй, чанарын талаар гаргасан алдааг илрүүлж, шалтгааныг арилгуулах;

11.10. шинжилгээнд ашигласан дээжийг холбогдох зааврын дагуу биоаюулгүйн шаардлагад нийцүүлэн хадгалах, өөр байгууллагад шилжүүлэх, эсхүл устгах ажлыг дээж хүлээн авсан лаборатори хариуцах;

11.11. хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гоц халдварт өвчний онош баталгаажуулах шинжилгээний дүнг лавлагаа лабораториос албан ёсоор авснаас хойш хоёр цагийн дотор Засгийн газарт танилцуулж, нийтэд мэдээлэх.

Гурав. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

12. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19.1-д заасан шуурхай бүлэг ажиллана.

13. Шуурхай бүлэг нь мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13.1. мал, амьтны гоц халдварт өвчний улмаас халдварын голомтод учирсан хор уршгийг арилгах үйл ажиллагааг тухайн нутгийн захиргааны байгууллагатай хамтран шуурхай удирдан зохион байгуулах;

13.2. хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд халдварын голомтыг устгах, ажиллах хүч хэрэгслийг зохион байгуулах, мэргэжлийн анги болон нутгийн иргэдийг дайчлан ажиллуулах, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

13.3. өвчний цагийн байдлыг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор тогтмол үнэлж, шийдвэр гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

13.4. өвчний голомтыг устгах, тархалтыг таслан зогсоох, учирсан хохирлыг богино хугацаанд арилгахад шаардагдах халдваргүйжүүлэх бодис, техник хэрэгсэл, халдвар хамгааллын хувцас, ариутгалын тоног төхөөрөмж, бусад бараа, бүтээгдэхүүний тооцоог гаргаж тухайн нутгийн захиргааны байгууллага болон онцгой байдлын төв байгууллагад хүргүүлэх;

13.5. шуурхай бүлэг, мэргэжлийн ангийн ажиллах байр болон голомтын бүсэд холбоо, мэдээллийн сүлжээ бий болгох ажлыг зохион байгуулах;

13.6. хорио цээр, хязгаарлалт тогтоосон нутгийн зааг, бүсэд зорчигч, тээврийн хэрэгсэл орох, гарах, дамжин өнгөрөх цэг, зурвасыг гамшгийн болон мэргэжлийн хяналтын улсын байцаагч, мал эмнэлгийн болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран тогтоож, анхааруулсан тэмдэг тавиулах, харуул хамгаалалт ажиллуулах;

13.7. гоц халдварт өвчний эх үүсвэр, гаралт, дэгдэлт, тархалтын шалтгааныг нарийвчлан тогтоох талаар холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлэх;

13.8. халдварын голомтод байгаа байнгын оршин суугчдад хүнс, өргөн хэрэглээний бараа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нутгийн захиргааны байгууллагатай хамтран хүргэх;

13.9. халдварын тархалтаас сэргийлэх, голомтыг устгах ажлын хэрэгжилтэд хяналт тавих;

13.10. хорио цээрийн онцгой бүсээр дамжин өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгсэлд хяналт тавьж, нэвтрэх зөвшөөрөл олгох;

13.11. зэрлэг ан, амьтдын хөдөлгөөнд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд өвчний тандан шинжилгээ хийх асуудлыг байгаль орчны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

13.12. хорио цээр, хязгаарлалтын бүсэд байгаа байнгын оршин суугч болон тэнд ажиллаж байгаа хүмүүсийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах, хяналт тавих, халдвараас сэргийлэх талаар мэдээлэл хийж аюулгүй ажиллах нөхцөлөөр хангах.

14. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд мал эмнэлгийн нарийн мэргэжлийн, хяналтын, устгалын, шалган нэвтрүүлэх болон зорчигч тээврийн хэрэгсэл халдваргүйжүүлэх, хэв журам сахиулах зэрэг мэргэжлийн анги ажиллана.

15. Мэргэжлийн ангийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27.1.2-т заасны дагуу байгуулна.

16. Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн анги нь хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд шуурхай бүлэг, нутгийн захиргааны байгууллагын удирдлага, дэмжлэгтэйгээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.1. мал, амьтны гоц халдварт өвчин гарсан нутгийн мал, амьтанд үзлэг, тандалт хийж өвчний тархалтын зааг хязгаарыг тогтоож байх;

16.2. өвчний халдварыг таслан зогсоох, голомтыг устгах арга хэмжээг зохион байгуулах үүрэгтэй мал эмнэлгийн удирдах болон үйлчилгээний нэгжүүдийн мэргэжилтэн оролцсон мэргэжлийн багийг байгуулан ажиллуулах;

16.3. гоц халдварт өвчнөөр өвчилсөн, үхсэн, өвчний сэжигтэй мал, амьтнаас холбогдох стандарт, зааврын дагуу дээж авах, дээжийг аймаг, бүс, улсын лабораторид хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

16.4. лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн өвчний тархалт, халдварын явц, байгаль орчин, хүн амын бөөгнөрөл, зам, тээврийн ачаалал зэрэг хүчин зүйлийг харгалзан дор дурдсан:

-халдварын голомт

-сэжигтэй

-хамгаалалтын

-эрүүл гэсэн 4 бүсийг тогтоох санал боловсруулах;

16.5. гоц халдварт өвчний ил шинж тэмдэгтэй болон лабораторийн шинжилгээгээр эерэг урвал үзүүлсэн мал, амьтныг богино хугацаанд ялган тусгаарлаж тухайн өвчинтэй тэмцэх зааврын дагуу шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

16.6. өвчний голомт дахь эрүүл мал, амьтанд үзлэг, тандалт хийж, уг өвчнөөс сэргийлэх вакцин хийх, устгалын цэг байгуулах, хашаа, хороо, уст цэг, малын тоног хэрэгслийг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах;

16.7. шаардагдах вакцин, халдваргүйжүүлэх бодис, бэлдмэл, техник хэрэгслийг захиалах, хуваарилах, өвчинтэй тэмцэх үйл ажиллагаанд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг татан оролцуулах;

16.8. өвчтэй малыг устгах ажлыг холбогдох зааврын дагуу холбогдох мэргэжлийн ангитай хамтран зохион байгуулж, устгал, ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн тухай акт үйлдэх;

16.9. өвчний цагийн байдлын талаарх мэдээ, мэдээллээр шуурхай бүлэг, нутгийн захиргааны байгууллагыг хангах;

16.10. тээврийн хэрэгсэл, хувцас хэрэглэл халдваргүйжүүлэх цэгийг голомт болон сэжигтэй бүсийн хөдөлгөөний гол чиглэлүүдэд холбогдох мэргэжлийн ангиудтай хамтран байгуулах;

16.11. өвчний эх үүсвэр, дэгдэлт, гаралт, тархалтын шалтгааныг нарийвчлан тогтоох тандалтын багийг зохион байгуулах.

17. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон үед гамшгаас хамгаалах болон мэргэжлийн хяналтын байгууллага нь шуурхай бүлэг, нутгийн захиргааны байгууллагын удирдлага, дэмжлэгтэйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1. гамшгаас хамгаалах болон мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар холбогдох хууль тогтоомжийн дагуу гоц халдварт өвчний голомтыг устгах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

17.2. хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүс нутгаас халдвар алдагдах, улсын хилээр халдвар орохоос сэргийлэх зорилгоор байнгын болон хөдөлгөөнт эргүүл ажиллуулах;

17.3. шуурхай бүлгээс олгосон зөвшөөрлийг үндэслэн хорио цээр, хязгаарлалтын бүсээр дамжин өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хорио цээр, хязгаарлалтын бүсийн хүн ам, мал, амьтны хөдөлгөөнд хяналт тавих;

17.4. хорио цээрийн дэглэм зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж энэ тухай шуурхай бүлгийн даргад илтгэх.

18. Гоц халдварт өвчнөөр үхсэн мал, сэг, зэм устгах мал эмнэлэг, цагдаа, онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн мэргэжлийн анги, шуурхай бүлэг, нутгийн захиргааны байгууллагын удирдлага, дэмжлэгтэйгээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1. устгал хийх мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах;

18.2. устгал хийх ажиллагаанд хэрэглэгдэх техник хэрэгсэл, хамгаалах хувцас, химийн бодис, галт хэрэгсэл, устгал хийх нүхийг зааврын дагуу бэлтгэх;

18.3. гоц халдварт өвчний ил шинж тэмдэгтэй болон лабораторийн шинжилгээгээр эерэг урвал үзүүлсэн мал, тэжээвэр амьтдыг малын эмчийн үйлдсэн актыг үндэслэн хүлээн авч зааврын дагуу устгах ажлыг гүйцэтгэх;

18.4. устгасан мал, амьтдыг булшлах ажлыг гүйцэтгэж, орчныг халдваргүйжүүлэн хашаа хамгаалалт хийж, анхааруулах тэмдэг тавьж аймаг, сумын засаг захиргааны болон мэргэжлийн байгууллагад албан ёсоор хүлээлгэн өгөх;

18.5. өвчтэй малыг устгасан ажлын гүйцэтгэлийн талаар шуурхай бүлэгт цаг тухайд нь илтгэх.

19. Шалган нэвтрүүлэх болон зорчигч, тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх мэргэжлийн анги нь шуурхай бүлэг, нутгийн захиргааны байгууллагын удирдлага, дэмжлэгтэйгээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.1. халдварын голомт бүхий газраар дамжин өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх, шалган нэвтрүүлэх суурин болон явуулын байрыг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан байгуулах;

19.2. халдваргүйжүүлэх бодис, бэлдмэлээс дээж авч лабораторийн шинжилгээнд илгээж баталгаа гаргуулах, тэдгээрийн нөөцийг бүрдүүлэх;

19.3. хорио цээр, хязгаарлалтын бүсээр дамжин өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгсэлд шуурхай бүлгээс олгосон тусгай зөвшөөрлийн баримт бичгийг үндэслэн бүртгэл хөтөлж, зохих зааврын дагуу халдваргүйжүүлж нэвтрүүлэх;

19.4. голомтын бүсэд оруулах хүнс, бараа, бусад зүйлийг тогтоосон цэгт тусгайлан бэлтгэсэн талбай /тавцан/-д буулгаж сэлгүүлэн хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

19.5. голомтын бүсэд байгаа хүн ам, ердийн болон авто тээврийн хэрэгслийг нэг бүрчлэн бүртгэж тэдгээрийн хөдөлгөөнд хяналт тавих;

19.6. хорио цээр, хязгаарлалтын дэглэм цуцлагдсан үед шалган нэвтрүүлэх байранд үүрэг гүйцэтгэсэн нийт бие бүрэлдэхүүний хувцас, багаж хэрэгслийг халдваргүйжүүлэх.

20. Хэв журам сахиулах мэргэжлийн анги нь шуурхай бүлэг, нутгийн захиргааны байгууллагын удирдлага, дэмжлэгтэйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.1. хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд холбогдох хууль тогтоомж, журмын дагуу харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих;

20.2. хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд гэмт хэрэг, хэв журмын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх;

20.3. шалган нэвтрүүлэх болон зорчигч, тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх цэгүүдэд дэг журам сахиулах;

20.4. хорио цээр, хязгаарлалтын бүсэд байгаа хүн амын дунд нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

Дөрөв. Иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг

21. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон үед холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг дагаж мөрдөх.

22. Мал эмнэлгийн үзлэг, сэргийлэх тарилгад мал, тэжээвэр амьтнаа бүрэн хамруулах, шаардагдах хашаа, байр, хүн хүчээр хангах, малыг байнгын хариулгатай байлгаж, арчилгаа, маллагааг сайжруулах.

Тав. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон нутаг дэвсгэрт хориглох зүйл

23. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон нутаг дэвсгэрт дараахь үйл ажиллагааг хориглоно:

23.1. зөвшөөрөгдсөнөөс бусад газраар хүн, мал, тэжээвэр амьтан, тээврийн хэрэгсэл орох, гарах, дамжин өнгөрөх;

23.2. мэргэжлийн болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бэлчээр, нутаг сэлгэх, хүн, мал, тэжээвэр амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт, хөдөлгөөн хийх, нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, хүн, мал, амьтны бөөгнөрөл бий болгох;

23.3. мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, тээвэрлэх, ахуйн хэрэглээнд мал нядлах;

23.4. өвчтэй мал, амьтны хашаа, байр, тоног төхөөрөмжийг халдваргүйжүүлэлгүйгээр хэрэглэх, малын хашаа, байранд мал эмнэлэг, хяналтын ажилтны зөвшөөрөлгүйгээр гадны хүн оруулах;

23.5. халдварын голомтын болон сэжигтэй бүсэд мал, амьтныг нийлүүлэх;

23.6. халдварын голомтын болон сэжигтэй бүсэд үйлчилдэг авто тээврийн хэрэгсэл, ердийн хөсгийг халдваргүйжүүлэхгүйгээр тайван бүсэд тээвэр хийлгэх.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 08 дугаар сарын 13-ны өдөр | Дугаар 316 | Улаанбаатар хот

**Үндэсний хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр хянан тусгаж хандивлагчдын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авч, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Сангийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "Үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 120 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Н.БОЛОРМАА**

**Засгийн газрын 2008 оны 316 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт**

## СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭХ, МЭРГЭШИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Манай улсад өнөөгийн байдлаар мэргэжлийн багшийн хангалт 95.7 хувь, багш ашиглалтын байдал 137.0 хувь байгаа боловч бэлтгэгдсэн боловсон хүчний тогтвор суурьшил, мэдлэг чадвар хангалтгүй, мэргэжлийн бус хүн ажиллаж байгаа зэрэг нь чанарын шаардлага бүрэн хангахгүй байна.

Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлэх үйл ажиллагаа удаашралтай, бага, дунд боловсролын шинэчлэлийн хурдаас хоцорсон, багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн профессор багш нарын ур чадвар, сургалтын материаллаг болон технологийн орчин харилцан адилгүй байна.

Боловсролын шинэ стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд багш нарын мэдлэг чадвар, мэргэшил, арга зүйн чадавхийг байнга дээшлүүлэх, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд төрөөс цогц дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого зэрэг Монгол Улсын хөгжлийн бодлого, стратеги, урт болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг тодорхойлсон баримт бичгийн үзэл санаа, зарчмыг үндэслэн боловсруулав.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, хэрэгжүүлэх зарчим, зорилт

2.1 Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн (цаашид "хөтөлбөр" гэх) зорилго нь багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог ерөнхий боловсролын сургуулийн бүтцийн өөрчлөлт, цогц чадамжид суурилсан боловсролын стандарт болон сургалтын хөтөлбөрийг суралцагчдын эрэлт хэрэгцээнд тохируулан хэрэгжүүлэх чадвартай багш бэлтгэх, багшийн мэргэшил, арга зүйг тасралтгүй дээшлүүлэх, цаашид тогтвортой хөгжих нөхцөлийг хангахад оршино.

2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.2.1. боловсролын багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэх;

2.2.2. багшийн хөгжлийн талаархи олон улсын жишиг, чиг хандлагыг баримжаалах;

2.2.3. багш бүрийг мэргэшил, арга зүйн ур чадвараа системтэй дээшлүүлэх тэгш боломжоор хангах;

2.2.4. мэргэшил дээшлүүлэх сонголттой, нээлттэй, уян хатан, тасралтгүй үйлчилгээ авах боломжоор хангах;

2.2.5. багш нарын тогтвортой ажиллах, тасралтгүй хөгжихөд шаардлагатай таатай орчныг бүрдүүлэх;

2.2.6. сурагчийн сурлагын амжилт, багшийн ажил, сургуулийн болон боловсролын салбарын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ, оношилгооны шүтэлцээ, уялдаа холбоог хангах.

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь зорилтуудыг дэвшүүлж байна:

2.3.1. Зорилт 1. (ББ) "Багш" боловсролын зорилго, агуулга, бага, дунд боловсролын чанарыг тасралтгүй сайжруулах хэрэгцээ шаардлага, ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, хөв шинжийн онцлогт нийцсэн зах зээл дэх багшийн хөдөлмөрийн эрэлт нийлүүлэлтэд баримжаалсан, багш бэлтгэх нээлттэй, уян хатан, тогтвортой тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх:

-ББ1. "Багш" боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн мөрдөх;

-ББ2. багшийн мэргэжлээр суралцагчдын сургалтын чанарыг дээшлүүлэх;

-ББ3. багш бэлтгэх сургуулийн профессор багш нарын чадавхийг дээшлүүлэх;

-ББ4. "Багш" боловсролын талаархи судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх;

-ББ5. багш бэлтгэх сургуулийн технологийн болон материаллаг баазыг шинэчлэх;

-ББ6. багш бэлтгэдэг төрийн өмчийн сургуулийн санхүүгийн чадавхийг дээшлүүлэх.

2.3.2. Зорилт 2. (МД) Нийгмийн аж төрөх ёсонд нийцсэн, ажлын байран дээрээ багш тасралтгүй хөгжих бодит хэрэгцээнд суурилсан, сургууль төвтэй мэргэшил дээшлүүлэх нээлттэй, сонголттой, тогтвортой тогтолцоог хөгжүүлэх:

-МД1. ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангах;

-МД2. ажлын байран дээрээ багш мэргэшил дээшлүүлэхэд шаардлагатай технологийн болон материаллаг орчныг бүрдүүлэх;

-МД3. мэргэшил дээшлүүлэх сургалтын төрлийг нэмэгдүүлж, менежментийг сайжруулах;

-МД4. мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн чанар, менежментийг хариуцдаг тогтолцоо бий болгох;

-МД5. мэргэшил дээшлүүлэх сургалтын зардал, санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгох;

-МД6. багш нарын зорилтот бүлэг бүрт зориулан боловсролын шинэчлэлийн хэрэгжилтийг дэмжсэн сургалт зохион байгуулах.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Зорилт. (ББ1) "Багш" боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн мөрдөх:

3.1.1. ББ1.1 "Багш" мэргэжилтний загварыг шинэчлэн тодорхойлж, түүнд нийцсэн "Багш" боловсролын стандартыг боловсруулж мөрдөх;

3.1.2. ББ1.2 "Багш" боловсролын шинэ стандартад нийцсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан мөрдөж, байнга сайжруулж байх;

3.1.3. ББ1.3 багш, боловсролын удирдах болон мэргэжлийн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжилж байх;

3.1.4. ББ1.4 сургалтын хөтөлбөрт тусгагдсан багшлах дадлагын хэсгийн зохион байгуулалтыг институтчилах.

3.2. Зорилт. (ББ2) Багшийн мэргэжлээр суралцагчдын сургалтын чанарыг дээшлүүлэх:

3.2.1. ББ2.1 ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөөс багш мэргэжлээр элсэн амжилттай суралцаж байгаа оюутанд улсын төсвөөс тэтгэлэг олгох асуудлыг шийдвэрлэх;

3.2.2. ББ2.2 сургалтын төрийн сангийн зээлээр суралцаж багшийн мэргэжлээр төгссөн оюутны сурлагын амжилт болон ажлын үр дүнг харгалзан сургалтын төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх механизм бий болгох;

3.2.3. ББ2.3 багш мэргэжлээр суралцагчдыг мэргэжлийн сурах бичгээр хангах асуудлыг шийдвэрлэх;

3.2.4. ББ2.4 багш мэргэжлээр суралцагчдын оюутны байрыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэх.

3.3. Зорилт. (ББ3) Багш бэлтгэх сургуулийн профессор багш нарын чадавхийг дээшлүүлэх:

3.3.1. ББ3.1 "Багш" боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадвартай боловсон хүчин бэлтгэх, чадавхижуулах цуврал сургалтыг тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;

3.3.2. ББ3.2 багш бэлтгэдэг сургуулийн профессор багш нарыг 6-12 сарын хугацаагаар сэлгэн ажиллуулж, туршлага судлуулах, сургалт, эрдэм шинжилгээний чиглэлээр мэргэшил дээшлүүлэх;

3.3.3. ББ3.3 багш бэлтгэдэг дотоодын их, дээд сургууль, коллеж болон гадаад орны ижил төрлийн сургууль хооронд тодорхой хөтөлбөрийн дагуу профессор багш нарыг солилцох, сургалт, судалгаа, мэргэшил, арга зүйн ур чадварыг нь дээшлүүлэх;

3.3.4 ББ3.4 багш бэлтгэдэг сургуулийн эрдэмтэн багш нарын суурь болон арга зүйн талаархи бүтээлийг шалгаруулах механизмыг бий болгох.

3.4. Зорилт. (ББ4) "Багш" боловсролын талаархи судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх:

3.4.1. ББ4.1 боловсролын хавсарга болон туршилт судалгааны төслийг Монгол Улсын их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургуульд төвлөрүүлэн боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар гүйцэтгүүлэх;

3.4.2. ББ4.2 Монгол Улсын их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэл болох боловсрол судлал, монгол судлалыг улсын төсөв болон гадаадын эх үүсвэрээс санхүүжүүлдэг болох;

3.4.3. ББ4.3 "Залуу багш, судлаач бэлтгэх, дэмжих хөтөлбөр" боловсруулан хэрэгжүүлж залуу багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтныг дотоод, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах;

3.4.4. ББ4.4 сайдын нэрэмжит шагнал бий болгож "Тэргүүний судлаач залуу багш", "Тэргүүний судлаач оюутан"-ыг жил бүр шалгаруулан урамшуулдаг болох.

3.5. Зорилт. (ББ5) Багш бэлтгэх сургуулийн технологийн болон материаллаг баазыг шинэчлэх:

3.5.1. ББ5.1 "Багш" боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай номын сан, лаборатори, тоног төхөөрөмж, мэдээлэл харилцааны технологи ашиглах сургалтын орчны стандарт боловсруулж мөрдөх;

3.5.2. ББ5.2 сургалтын орчны стандартад нийцсэн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг нийлүүлж, сургалт, судалгааны технологийн болон материаллаг орчныг сайжруулах;

3.5.3. ББ5.3 Монгол Улсын Боловсролын их сургуулийн Монгол судлалын сургууль, Түүх, нийгмийн ухааны сургууль, Боловсрол судлалын сургуулийн сургалт, судалгааны технологийн болон материаллаг орчныг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт хийх.

3.6. Зорилт. (ББ6) Багш бэлтгэдэг төрийн өмчийн сургуулийн санхүүгийн чадавхийг дээшлүүлэх:

3.6.1. ББ6.1 багш бэлтгэдэг сургуульд тогтмол зардал олгож байх;

3.6.2. ББ6.2 багш бэлтгэдэг төрийн өмчийн сургуулийн багш, ажилтны цалинг төсвөөс олгох асуудлыг шийдвэрлэх;

3.6.3. ББ6.3 багш бэлтгэдэг сургуулийн хувьсах зардлыг төсөвт тусган санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх.

3.7. Зорилт. (МД1) Ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангах:

3.7.1. МД1.1 сум, тосгон, багт ажиллаж байгаа сургууль, цэцэрлэгийн багшаас бусад удирдах болон мэргэжлийн албан тушаалтанд 5 жил тутамд 6 сарын тэтгэлэг олгох асуудлыг судалж холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлж хэрэгжүүлэх;

3.7.2. МД1.2 багшийн ажлын байрыг хөдөлмөрийн биржээр дамжуулан хангах арга хэмжээ авах;

3.7.3. МД1.3 багшийн ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтад үзүүлэх нөлөө, хариуцлагыг дэмжсэн урамшууллын механизмтай уялдуулж багшлах эрх, багшийн мэргэшлийн зэрэг олгох журмыг шинэчлэн мөрдөх;

3.7.4. МД1.4 багшийн ажлын чанар, хөдөлмөрийн үр бүтээлийн үнэлгээг боловсролын чанарын үнэлгээний шинэ тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгох.

3.8. Зорилт. (МД2) Ажлын байран дээрээ багш мэргэшил дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай технологийн болон материаллаг орчныг бүрдүүлэх:

3.8.1. МД2.1 багш, ажилтан сургууль дээрээ мэргэшил дээшлүүлэх, бүтээлчээр ажиллах нөхцөл бүрдүүлэхэд шаардлагатай технологийн болон материаллаг орчны стандарт боловсруулж мөрдөх;

3.8.2. МД2.2 орон нутгийн өмчийн бүх сургуулийн багш нарын өрөө-ажлын байрыг стандартын шаардлагын дагуу тохижуулах;

3.8.3. МД2.3 мэргэжлийн чиглэл бүрээр зайны сургалтын материал, хэрэглэгдэхүүн бэлтгэж багш нарт нийлүүлэх;

3.8.4. МД2.4 сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх болон сурагчийг үнэлэх, дүгнэхэд нь шаардлагатай программ хангамжаар хангах;

3.8.5. МД2.5 багш нарт зориулсан ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авахад төрөөс дэмжлэг үзүүлэх;

3.9. Зорилт. (МД3) Мэргэшил дээшлүүлэх сургалтын төрлийг нэмэгдүүлж, менежментийг сайжруулах:

3.9.1. МД3.1 багш, ажилтны мэргэшил дээшлүүлэх талаар холбогдох журам баталж мөрдөх;

3.9.2. МД3.2 багш ажиллах хугацаандаа 3-аас доошгүй удаа мэргэшил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагддаг тогтолцоо бий болгож, төлөвшүүлэх;

3.9.3. МД3.3 дээд боловсролтой боловч багшийн мэргэжилгүй багш нарыг мэргэжил эзэмшүүлэх болон тухайн мэргэшлийн багшид өөр мэргэшил олгон суралцуулах хөрвөх сургалтыг бий болгох;

3.9.4. МД3.4 мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагаа болон түүний үр дүнгийн мэдээлэл, хяналт-шинжилгээний тогтолцоог бий болгох.

3.10. Зорилт. (МД4) Мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн чанар, менежментийг хариуцдаг тогтолцоо бий болгох:

3.10.1. МД4.1 багшлах эрх олгох, мэргэшлийн зэрэг олгох, мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагааг уялдуулах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий "Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт" байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх;

3.10.2. МД4.2 мэргэшил дээшлүүлэх үндсэн болон кредит олгох төрөлжсөн сургалтын хөтөлбөрт магадлан шинжилгээ хийж шалгаруулдаг механизм бүрдүүлэх;

3.10.3. МД4.3 мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт магадлан шинжилгээ хийх шинжээч, сургагч багш нарыг бэлтгэх;

3.10.4. МД4.4 сургууль, цэцэрлэгийн "Заах аргын нэгдэл"-ийн бүтэц, үйл ажиллагааны арга хэлбэрийг уян хатан болгож, сургалтын хөтөлбөр боловсруулах, хичээл заах, дүн шинжилгээ хийхэд багаар ажиллах соёлыг бий болгох.

3.11. Зорилт. (МД5) Мэргэшил дээшлүүлэх сургалтын зардал, санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгох:

3.11.1. МД5.1 мэргэшил дээшлүүлэх үндсэн сургалтын зардлыг улсын төсөвт жил бүр тусган санхүүжүүлж байх;

3.11.2. МД5.2 мэргэшил дээшлүүлэх зардлыг тусгай зүйлээр сургуулийн төсөвт тусгаж санхүүжүүлэх;

3.11.3. МД5.3 мэргэшил дээшлүүлэх кредит олгох болон бусад төрөлжсөн сургалт, хөрвөх сургалтыг эрэлтэд суурилсан санхүүжилттэй болгох.

3.12. Зорилт. (МД6) Багш нарын зорилтот бүлэг бүрт зориулан боловсролын шинэчлэлийн хэрэгжилтийг дэмжсэн сургалт зохион байгуулах:

3.12.1. МД6.1 мэргэшил дээшлүүлэх сургалтын үндэсний болон орон нутгийн түвшний дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж мөрдөх;

3.12.2. МД6.2 багш, удирдах болон мэргэжлийн ажилтны мэргэшил дээшлүүлэх сургалтын модулийн тогтолцоо боловсруулж, магадлан шинжилгээ хийж бүртгэх;

3.12.3. МД6.3 мэргэшил дээшлүүлэх, үндсэн, төрөлжсөн, хөрвөх, бие даах сургалт зохион байгуулах;

3.12.4. МД6.4 гадаад оронд багш нарыг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулж, дэвшилтэт туршлага, арга зүйг судлах, нэвтрүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа

4.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

4.1.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

4.1.2. хандивлагчдын зээл тусламжийн хөрөнгө;

4.1.3. сургалтын төрийн сангийн хөрөнгө;

4.1.4. шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгө;

4.1.5. сургалтын байгууллагын үйл ажиллагааны орлого;

4.1.6. бусад эх үүсвэр.

4.2. Хөтөлбөрийг 2009-2015 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн удирдлага, хяналт-шинжилгээ

5.1. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө болон холбогдох бусад төсөл, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх, салбарын яамдын уялдаа холбоог хангах, үндэсний болон орон нутгийн түвшинд нэгдмэл удирдлагыг бий болгох, хандивлагчид, олон улсын байгууллагын оролцоог уялдуулан зохицуулах асуудлыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага улсын хэмжээнд зохион байгуулна.

5.3. Үндэсний хөтөлбөрийн үе шат бүрийг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар эрхлэн гүйцэтгэнэ.

5.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөрийн зорилт тус бүрийн хүрэх үр дүнгийн болон шалгуур үзүүлэлтийн биелэлтээр гаргаж Засгийн газарт жил бүр танилцуулж байна.

Засгийн газрын 2008 оны 316 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

## СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭХ, МЭРГЭШИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа | Хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлт | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|
| Зорилт. (ББ1) "Багш" боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн мөрдөх | | | | |
| ББ1.1 | "Багш" мэргэжилтний загварыг шинэчлэн тодорхойлж, түүнд нийцсэн "Багш" боловсролын стандартыг боловсруулж мөрдөх<br><br>(2008-2009 оны хичээлийн жилээс) | -Багш боловсролын стандартыг шинэчлэн батлуулсан байна<br>-Бага, дунд боловсролын стандарт, сургалтын үндэсний хөтөлбөр, 12 жилийн сургалтын төлөвлөгөө хэрэгжих зайлшгүй нөхцөл бүрдэнэ | Дараахь шалгуурыг хангасан байна:<br>-"Багш" боловсролын хөгжлийн чиг хандлагад нийцсэн байдал<br>-Багшийн ажлын байрны тодорхойлолтод туссан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар эзэмшүүлэх баталгаа | БСШУЯ<br>Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв,<br>МУБИС,<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ1.2 | "Багш" боловсролын шинэ стандартад нийцсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан мөрдөж, байнга сайжруулж байх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Багш боловсролын шинэ стандартад нийцсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр батлагдаж сургалтад мөрдөгдөж эхэлнэ<br>-Шинэ хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу багш бэлтгэх үндсэн сургалт явагдана<br>-Багшийн мэргэжил болон мэргэшлээрээ хөрвөх, нягтруулсан хугацаатай хувилбарт сургалт явагдаж эхэлнэ | -Сургуулийн бүтэц, хэв шинжийн онцлогт нийцсэн байдал<br>-Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн агуулгын бүтэц, харьцаа, хувилбарууд<br>-Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулалт, арга хэлбэрийн уян хатан чанар<br>-Бэлтгэгдэх багшийн мэргэжлийн хослол, шилжиж хөрвөх боломж<br>-Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ | БСШУЯ<br>МУИС, МУБИС,<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ1.3 | Багш, боловсролын удирдах болон мэргэжлийн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжилж байх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Багш, боловсролын удирдах болон мэргэжлийн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийн чанар сайжрах нөхцөл бүрдэнэ | -Магадлан итгэмжлүүлэхээр холбогдох байгууллагад ирүүлсэн хөтөлбөрийн тоо (жилээр, мэргэжлийн чиглэлээр)<br>-Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо (жилээр, мэргэжлийн чиглэлээр) | БСШУЯ<br>Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл,<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ1.4 | Сургалтын хөтөлбөрт тусгагдсан багшлах дадлагын хэсгийн зохион байгуулалтыг институтчилах<br><br>(2010-2011 оны хичээлийн жилээс) | -Бэлтгэгдэж байгаа багш нар сургууль, цэцэрлэгийн орчинд дадлагаждаг болно | -Дадлага авдаг сургууль, цэцэрлэгийн тоо (жилээр, мэргэжлийн чиглэлээр)<br>-Нэг оюутны дадлагад зарцуулах зардлын бүтэц (зардлын зүйлээр)<br>-Нэг оюутны дадлагад улсын төсвөөс зарцуулах зардлын хэмжээ (жилээр) | БСШУЯ<br>СЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Зорилт. (ББ2) Багшийн мэргэжлээр суралцагчдын сургалтын чанарыг дээшлүүлэх | | | | |
| ББ2.1 | Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөөс багш мэргэжлээр элсэн амжилттай суралцаж байгаа оюутанд улсын төсвөөс тэтгэлэг олгох асуудлыг шийдвэрлэх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Их, дээд сургуульд элсэгчдээс багшийн мэргэжлээр суралцах сонирхол, өрсөлдөөн нэмэгдэнэ<br>-Элсэгчдийн чанар дээшилснээр төгсөгчдийн багшийн чанар нэмэгдэнэ | -Элсэлтийн ерөнхий шалгалтанд авсан оноо<br>-Тэтгэлэг авах шаардлага хангасан оюутны тоо (хичээлийн жилээр мэргэшлээр)<br>-Нэг оюутанд нэг сард олгох тэтгэлгийн хэмжээ<br>-Тэтгэлэг олгоход зарцуулсан нийт зардал (хичээлийн жилээр, эх үүсвэрээр) | БСШУЯ<br>СЯ<br>Сургалтын төрийн сан,<br>Багш бэлтгэдэг сургууль, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |
| ББ2.2 | Сургалтын төрийн сангийн зээлээр суралцаж багшийн мэргэжлээр байгаа оюутны сурлагын амжилт болон ажлын үр дүнг харгалзан сургалтын төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх механизм бий болгох<br>(2010-2011 оны хичээлийн жилээс) | -Сургалтын төлбөрийн зээлийн үр өгөөж нэмэгдэнэ<br>-Оюутны сурлагадаа хандах хариуцлага дээшилнэ<br>-Залуу багш ажиллах явцдаа ур чадвараа хөгжүүлэх эрмэлзэлтэй болно | -Элсэлт, төгсөлтийн урсгал<br>-Дутагдалтай багшийн тоо<br>-Төрийн сангийн зээлд багш боловсролоор суралцагчдын эзлэх хувь<br>-Тухайн жилийн төгсөгчдөөс багшаар ажиллагсдын хувь | БСШУЯ<br>СЯ, Сургалтын төрийн сан,<br>Багш бэлтгэдэг сургууль, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |
| ББ2.3 | Багш мэргэжлээр суралцагчдыг мэргэжлийн сурах бичгээр хангах асуудлыг шийдвэрлэх<br>(2010-2011 оны хичээлийн жилээс) | -Ерөнхий болон тусгай дидактикийн чиглэлээр чанартай сурах бичиг гарна | -Сурах бичиг зохиоход тавигдах шаардлага (ерөнхий, тусгай)<br>-Сурах бичиг шалгаруулахад баримтлах зарчим | БСШУЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ2.4 | Багш мэргэжлээр суралцагчдын оюутны байрыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Дотуур байранд амьдрах оюутны тоо нэмэгдсэнээр тэд хичээл сурлагадаа төвлөрч, нийгмийн сөрөг нөлөөлөлд автах явдал багасна<br>-Ес зүйтэй багш нар бэлтгэгдэх нэг нөхцөл хангагдана | -Нэмэгдсэн орны тоо (жилээр, сургуулиар)<br>-Нэг оюутанд ногдох талбай ($м^2$ сургуулиар)<br>-Нэг ор нэмэгдүүлэхэд зарцуулсан зардал (жилээр, сургуулиар) | БСШУЯ<br>СЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| Зорилт. (ББ3) Багш бэлтгэх сургуулийн профессор багш нарын чадавхийг дээшлүүлэх | | | | |
| ББ3.1 | "Багш" боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадвартай боловсон хүчнийг бэлтгэх, чадавхижуулах цуврал сургалтыг тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулах<br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Сургалтын агуулга, арга зүй, зохион байгуулалтын уялдаа холбоо сайжирна<br>-Багш бүр сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлнэ | -Төлөвлөгөөний төрөл, хугацаа<br>-Профессор багшийн ур чадварын өсөлтийн индикаторууд<br>-Мэргэшлийн зэрэг, дэвийн бүтэц, ур чадварын түвшний харьцаа | БСШУЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ3.2 | Багш бэлтгэдэг сургуулийн профессор багш нарыг 6-12 сарын хугацаагаар сэлгэн ажиллуулж туршлага судлуулах, сургалт, эрдэм шинжилгээний чиглэлээр мэргэшил дээшлүүлэх<br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -"Багш" боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг төвийн болон харьяа сургуульд ижил түвшинд хэрэгжүүлэх нөхцөл хангагдана | -Профессор багш нарын нас, хүйс, боловсрол ба мэргэшлийн зэрэг дэвийн бүтэц ба ур чадварын түвшний харьцаа зохимжтой болно | Багш бэлтгэдэг сургууль |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ББ3.3 | багш бэлтгэдэг дотоодын их, дээд сургууль, коллеж болон гадаад улсын ижил төрлийн сургууль хооронд тодорхой хөтөлбөрийн үндсэн дээр профессор багш нарыг солилцох, сургалт, судалгаа, мэргэшил, арга зүйн ур чадварыг нь дээшлүүлэх (2010-2011 оны хичээлийн жилээс) | -"Багш" боловсролын чиглэлээр гадаад орнуудад явагдаж байгаа сургалт, судалгааны ажилтай танилцаж, харилцан туршлага судалж, олон улсын жишигт хүрэх нөхцөл бүрдэнэ | -Гадаадад суралцсан багш, судлаачийн тоо (жилээр, агуулгын чиглэлээр)<br>-Солилцоо хийсэн улсын нэр (жилээр)<br>-Солилцоо хийхэд зарцуулсан зардлын хэмжээ (жилээр, эх үүсвэрээр, зардлын зүйлээр) | БСШУЯ<br>СЯ<br>ГХЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ3.4 | Багш бэлтгэдэг сургуулийн эрдэмтэн багш нарын суурь болон арга зүйн чиглэлийн чансаатай бүтээлийг шалгаруулах механизмыг бий болгох<br><br>(2010 оноос) | -Монгол Улсын хөгжлийн түүхэн онцгой үеийн онол, арга зүйн сэтгэлгээний өөрчлөлтийг дархалсан бүтээл бий болно<br>-Судлаачийг урамшуулах механизм бүрдэнэ | -Чансаатай бүтээл шалгаруулахад тавигдах шаардлага, зарчим<br>-Бүтээл шалгаруулах арга<br>-Зохиогчийн олох орлого, урамшууллын хэмжээ (жилээр, бүтээлийн төрлөөр) | БСШУЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| Зорилт. (ББ4) "Багш" боловсролын талаарх судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх | | | | |
| ББ4.1 | Боловсролын хавсарга болон туршилт судалгааны төслийг Монгол Улсын их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургуульд төвлөрүүлэн боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар гүйцэтгүүлэх<br>(2009 оноос) | -Хавсарга болон туршилт судалгаа явуулах боловсон хүчний чадавхи дээшилнэ<br>-Багш бэлтгэх болон мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагааг холбох боломж бүрдэнэ | -боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын болон бусад байгууллагын захиалгаар гүйцэтгэсэн төслийн тоо (жилээр, агуулгын чиглэлээр)<br>-Төслийн нийт өртөг (жилээр, төсөл бүрээр) | БСШУЯ<br>Шинжлэх ухаан технологийн сан,<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ4.2 | Монгол Улсын их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэл болох боловсрол судлал, монгол судлалыг улсын төсөв болон гадаадын эх үүсвэрээс санхүүжүүлдэг болох<br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Нэрлэгдсэн тэргүүлэх чиглэлээр дорвитой судалгаа хийгдэх санхүүгийн боломж бүрдэж, судалгааны үр дүн нь боловсролын хөгжилд бодитой хувь нэмэр оруулна | -Судалгааны үр дүн, сургалт, судалгааны практикт нэвтэрсэн байдал (жилээр, тэргүүлэх чиглэл бүрээр)<br>-Судалгааны санхүүжилтийн хэмжээ (жилээр, тэргүүлэх чиглэл бүрээр, эх үүсвэрээр) | БСШУЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ4.3 | "Залуу багш, судлаач бэлтгэх, дэмжих хөтөлбөр" боловсруулан хэрэгжүүлж залуу багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтныг дотоод, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах<br>(2010-2011 оны хичээлийн жилээс) | -Залуу судлаач багш нарын ур чадвар дээшилж, нийт багшийн боловсрол ба мэргэшлийн зэргийн бүтэц, ур чадварын түвшний харьцаа зохистой болно | -Боловсролын болон мэргэшлийн зэргээ ахиулсан залуу багш нарын тоо (жилээр, мэргэжлийн чиглэлээр)<br>-Нийт багшийн боловсрол ба мэргэшлийн зэргийн бүтэц, ур чадварын түвшний харьцаа | БСШУЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ4.4 | Сайдын нэрэмжит шагнал бий болгож, "Тэргүүний судлаач залуу багш", "Тэргүүний судлаач оюутан"-ыг жил бүр шалгаруулан урамшуулдаг болох<br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Залуу багш, оюутныг урамшуулж дэмжих механизмтай болсноор багш нь судалгааны арга зүйд идэвхтэй суралцана | -"Тэргүүний судлаач залуу багш" болон "Тэргүүний судлаач оюутан"-ы тоо (жилээр, сургуулиар, судалгааны чиглэлээр)<br>-Тэргүүний багш, оюутанд олгох шагналын төрөл, хэмжээ (жилээр) | БСШУЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Зорилт. (ББ5) Багш бэлтгэх сургуулийн технологийн болон материаллаг баазыг шинэчлэх | | | | |
| ББ5.1 | "Багш" боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай номын сан, лаборатори, тоног төхөөрөмж, мэдээлэл харилцааны технологи ашиглах сургалтын орчны стандарт боловсруулж мөрдөх (2009-2010 оны хичээлийн жилээс) | -Багш бэлтгэдэг сургуулийн материаллаг баазыг сайжруулах эрэлт хэрэгцээг нарийвчлан тодорхойлсноор нийлүүлэлтийн чанарын баталгааг хангах нөхцөл бүрдэнэ | -Багш боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байх<br>-Сургалтын технологийн шинэчлэлийн шаардлага хангасан, чанартай, эдэлгээтэй | БСШУЯ<br>Шинжлэх ухаан технологийн сан,<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ5.2 | Сургалтын орчны стандартад нийцсэн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг нийлүүлж, сургалт, судалгааны технологийн болон материаллаг орчныг сайжруулах<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Орчин үеийн технологи, арга зүйн дагуу сургалт, судалгаа явуулах төрөлжсөн кабинет, лабораториудтай болно | -Кабинет, лаборатори бүрийн зориулалт, хүчин чадал (жилээр, сургуулиар, сургалт, судалгааны чиглэлээр)<br>-Кабинет, лаборатори бүрийг байгуулах, шинэчлэхэд зарцуулсан зардлын хэмжээ (жилээр, эх үүсвэрээр, сургалт, судалгааны чиглэлээр) | БСШУЯ<br>СЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ5.3 | Монгол Улсын Боловсролын их сургуулийн Монгол судлалын судалгаа явуулдаг Монгол судлалын сургууль, Түүх, нийгмийн ухааны сургууль, Боловсрол судлалын сургуулийн сургалт, судалгааны технологийн болон материаллаг орчныг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт хийх (2010-2011 оны хичээлийн жилээс) | -Оюутан болон профессор багш нарын багшлах, суралцах, судалгаа хийх орчин нөхцөл сайжирна | -Хөрөнгө оруулалтын зориулалт (жилээр, сургуулиар)<br>-Тоног төхөөрөмжийн хүчин чадал (жилээр, сургуулиар, сургалт, судалгааны чиглэлээр)<br>-Хөрөнгө оруулалтын хэмжээ (жилээр, эх үүсвэрээр, сургуулиар) | БСШУЯ<br>СЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| Зорилт. (ББ6) Багш бэлтгэдэг төрийн өмчийн сургуулийн санхүүгийн чадавхийг дээшлүүлэх | | | | |
| ББ6.1 | Багш бэлтгэдэг сургуульд тогтмол зардал олгож байх<br><br>(2008-2009 оны хичээлийн жилээс) | -Сургалтын төлбөрийг сургалт, судалгааныхаа технологи, арга зүй, орчин нөхцөлийг сайжруулахад чиглүүлж зориулалтаар нь зарцуулах боломж бүрдэнэ | -Жил бүр улсын төсвөөс олгосон тогтмол зардлын хэмжээ (сургуулиар) | БСШУЯ<br>СЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ6.2 | Багш бэлтгэдэг төрийн өмчийн сургуулийн багш, ажилтны цалинг төсвөөс олгох асуудлыг шийдвэрлэх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Багш бэлтгэдэг сургуулийн багш нар төрийн үйлчилгээний албан хаагчийн ангилал, зэрэглэлийн дагуу цалин хөлсийг улсын төсвөөс авах эрх хангагдана. | -Багш, ажилтны албан тушаалын зэрэглэл (албан тушаал бүрээр)<br>-Багш, ажилтны үндсэн цалингийн доод жишиг (албан тушаал бүрээр) | БСШУЯ<br>НХХЯ<br>СЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| ББ6.3 | Багш бэлтгэдэг сургуулийн хувьсах зардлыг төсөвт тусган санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх<br><br>(2010-2011 оны хичээлийн жилээс) | -Сургууль, цэцэрлэгийн орчинд ажиллах чадвартай багш бэлтгэгдэх гол нөхцөл хангагдана | -Тухайн хичээлийн жилд дадлага хийх оюутны тоо (сургуулиар, ангиар, мэргэжлээр)<br>-Нэг оюутанд ногдох багшлах дадлагын зардлын хэмжээ (жилээр, зардлын зүйлээр) | БСШУЯ<br>СЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Зорилт. (МД1) Ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангах | | | | |
| МД1.1 | Сум, тосгон багт ажиллаж байгаа сургууль, цэцэрлэгийн багшаас бусад удирдах болон мэргэжлийн албан тушаалтнуудад 5 жил тутамд 6 сарын тэтгэлэг олгох эрх зүйн орчныг бүрдүүлж хэрэгжүүлэх (2010-2011 оны хичээлийн жилээс) | -Чадварлаг багш нарын хөдөө ажиллах сонирхол нэмэгдэж, мэргэжлийн багшаар хангагдана -Хот, хөдөөд багш ашиглалтын хувийн жин 100 хувьд хүрнэ -Багш нарын нас, хүйсийн харьцаа зохистой болно | -Мэргэжлийн багшийн хангалтын хувь -Багш ашиглалтын хувийн жин -Сум, тосгон, багт шилжин ажилласан багшийн тоо (насаар, мэргэжлээр) -Хүйсийн тэгш байдал -Насны бүтэц | БСШУЯ Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |
| МД1.2 | Багшийн ажлын байрыг хөдөлмөрийн биржээр дамжуулан хангах арга хэмжээ авах (2009-2010 оны хичээлийн жилээс) | -Багшийн ажлын байрны сул орон тоог мэргэжлийн багш нараар хангах мэдээлэл солилцооны механизм бүрдэнэ | -Хөдөлмөрийн биржээр багшийн ажилтай болсон хүний тоо (жил бүрээр) -Дутагдалтай багшийн тоо | БСШУЯ НХХЯ Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |
| МД1.3 | Багшийн ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтад үзүүлэх нөлөө хариуцлагыг дэмжсэн урамшууллын механизмтай уялдуулан багшлах эрх, багшийн мэргэшлийн зэрэг олгох журмыг шинэчлэн мөрдөх (2008-2009 оны хичээлийн жилээс) | -Багшлах эрх нь багш мэргэжлийн дипломтой хүмүүс, өөрийгөө турших, чадвартай багшийг сонгон шалгаруулах, мэргэшлийн зэрэг нь багшийн ур чадварын өсөлтийг хангах тус тус хэрэгсэл болсон байна | -Багшлах эрхийн баталгааг хангасан байдал -Багшийн мэргэшлийн ур чадварын бодит хөгжлийг үнэлсэн, дэмжсэн байдал -Багшид эрх олгох, мэргэшлийн зэрэг олгох, мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагаағ уялдуулсан шийдэл | БСШУЯ ХЗДХЯ Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |
| МД1.4 | Багшийн ажлын чанар, хөдөлмөрийн үр бүтээлийн үнэлгээг боловсролын чанарын үнэлгээний шинэ тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгох (2009-2010 оны хичээлийн жилээс) | -Боловсролын стандартын хэрэгжилтийн чанар бодитоор үнэлэгддэг болно -Багшийн ажлыг үнэлэх субъектив нөлөөлөл буурна | -Тухайн багшийн стандартын хэрэгжилтийг хангасан үр дүнг үндэсний, орон нутгийн, сургалтын байгууллагын түвшинд харьцуулах, үнэлэх технологийн шийдлийн түвшин | БСШУЯ Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |
| Зорилт. (МД2) Ажлын байран дээрээ багш мэргэшил дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай технологийн болон материаллаг орчныг бүрдүүлэх | | | | |
| МД2.1 | Багш, ажилтан сургууль дээрээ мэргэшил дээшлүүлэх, бүтээлчээр ажиллах нөхцөл бүрдүүлэхэд шаардлагатай технологийн болон материаллаг орчны стандарт боловсруулж мөрдөх (2009-2010 оны хичээлийн жилээс) | -Сургалтын байгууллагын холбогдох мэдээлэл харилцааны технологи нэвтрүүлэх, интернетэд холбогдох болон материаллаг орчинд тавигдах шаардлага тодорхойлогдож, нийлүүлэлт, ашиглалтын чанар баталгаатай болсон байна | -Интернетийн хурд, ашиглах хугацаа -Интернет ашиглахад зарцуулсан зардлын хэмжээ -Интернет ашиглалтын цаг, тоног төхөөрөмж, сандал ширээ, ном, гарын авлага зэргийн нэг багшид ногдох хувь хэмжээ | БСШУЯ Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| МД2.2 | Орон нутгийн өмчийн бүх сургуулийн багш нарын өрөө-ажлын байрыг тогтоогдсон стандартын дагуу тохижуулах<br><br>(2010-2011 оны хичээлийн жилээс) | -Багш нар сургууль дээрээ бүтээлчээр ажиллах орчин нөхцөл бүрдсэн байна<br>-Багш нар хамтран ажиллах бодит боломж бүрдэнэ<br>-Хичээлийн бэлтгэлийн чанар сайжирна<br>-Багш ажлын цагаа бүрэн, үр бүтээлтэй ашигладаг болно | -Нэг багшид ногдох ажлын өрөөн дэх суудлын тоо<br>-Стандартын дагуу тоноглогдсон сургуулийн тоо (жилээр)<br>-Хөрөнгө оруулалтаас нэг багшид ногдох зардлын хэмжээ<br>-Хот, хөдөөгийн сургуулийн багшийн ажлын орчны тэгш боломж бүрдсэн байдал | БСШУЯ<br>Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар,<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |
| МД2.3 | Мэргэжлийн чиглэл бүрээр зайны сургалтын материал, хэрэглэгдэхүүн бэлтгэж багш нарт нийлүүлэх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Сургалтад шинэ арга зүй, мэдээлэл харилцааны технологи нэвтэрнэ<br>-Мэдээлэл харилцааны шинэ соёл, ёс зүй нэвтэрнэ | -Жил бүр нийлүүлэгдэх сургалтын хэрэглэгдэхүүн, программын тоо (мэргэжил бүрээр, анги бүрээр)<br>-Нэг багшид болон сургуульд ногдох хэрэглэгдэхүүний тоо | БСШУЯ<br>Багш бэлтгэдэг сургууль,<br>Боловсролын хүрээлэн, Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |
| МД2.4 | Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх болон суралцагчийг үнэлэх, дүгнэхэд нь шаардлагатай программ хангамжаар хангах<br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Электрон сургалтын арга зүйг багшлах арга зүйн салшгүй хэсэг болгосон байна | -Электрон сургалтын арга зүйг хэрэглэдэг багшийн тоо (мэргэжлээр) | БСШУЯ<br>Багш бэлтгэдэг сургууль,<br>Боловсролын хүрээлэн |
| МД2.5 | Багш нарт зориулсан ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авахад төрөөс дэмжлэг үзүүлэх<br>(2010-2011 оны хичээлийн жилээс) | -Багш бүр сургалтад хэрэглэх гарын авлага, хэрэглэгдэхүүн, бичиг хэргийн материалаар хангагддаг болно | -Нэг багшийн хэрэгцээнд зарцуулагдсан зардлын хэмжээ (жилээр, материалын төрлөөр, сургуулиар), эх үүсвэрээр | БСШУЯ<br>СЯ |
| Зорилт. (МДЗ) Мэргэшил дээшлүүлэх сургалтын төрлийг нэмэгдүүлж, менежментийг сайжруулах | | | | |
| МД3.1 | Багш, ажилтны мэргэшил дээшлүүлэх журам баталж мөрдөх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагааны менежмент боловсронгуй болно | -Хэрэглэгчдийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх, үйлчилгээний чанарын баталгаа хангах шийдэл<br>-Үйлчилгээний нээлттэй, тогтвортой, хөнгөн шуурхай байдлын шийдэл<br>-Үйлчлүүлэгчдэд тэгш боломжийг олгосон шийдэл<br>-Зардлын эх үүсвэр, санхүүжилтийн зарчмыг тодорхойлсон шийдэл | БСШУЯ<br>СЯ<br>ХЗДХЯ |
| МД3.2 | Багш ажиллах хугацаандаа 3-аас доошгүй удаа мэргэшил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагддаг тогтолцоо бий болгож төлөвшүүлэх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Мэргэжлийн багш бүр анхны болон 5, 10 дахь жилдээ 7, 14, 21 хоногийн сургалтад хамрагддаг болно<br>-Мэргэшил дээшлүүлэх үндсэн сургалтууд хэлбэржиж институтчилагдана | -Тухайн жилд мэргэшил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдсан багшийн тоо (сургалтын төрөл, мэргэжил бүрээр)<br>-Тухайн жилд үндсэн сургалт бүрээр зарцуулсан зардлын хэмжээ | БСШУЯ<br>СЯ<br>ХЗДХЯ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| МД3.3 | Дээд боловсролтой багшийн мэргэжилгүй багшийг мэргэшил эзэмшүүлэх болон тухайн мэргэжлийн багш нарыг өөр мэргэшил олгон суралцуулах хөрвөх сургалтыг бий болгох<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Мэргэжлээрээ хөрвөж, нарийн мэргэшлийн хүмүүс багш болох боломж нээлттэй болно<br>-Цөөн хүүхэдтэй сургуульд хэд хэдэн чиглэлээр мэргэшсэн багш бүрэн ачааллаар ажиллаж, мэргэжлийн багш дутагдах явдал багасна | -Багш мэргэжлээр бакалаврын боловсролын зэргийн дипломтой болох шаардлагууд<br>-Мэргэжлээрээ хөрвөж, багш мэргэжлээр суралцагчдын тоо<br>-Мэргэшлээрээ хөрвөж суралцагчдын тоо<br>-Мэргэжил болон мэргэшлээрээ хөрвөж, сургуульд багшилж байгаа багшийн тоо | БСШУЯ<br>Багш бэлтгэдэг сургууль |
| МД3.4 | Мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагаа болон түүний үр дүнгийн мэдээлэл, хяналт-шинжилгээний тогтолцоог бий болгох<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Мэргэшил дээшлүүлэх сургалтын тухай мэдээлэл, хяналт-шинжилгээний тогтолцоо бүрдэж, багш, ажилтанд үр чадвараа хөгжүүлэх агуулгаа сонгох, төлөвлөх боломж бүрдэнэ<br>-Мэргэшил дээшлүүлэх чиглэлээр мэдээллийн нэгдсэн сан бүрдэж, судалгаа, бодлого боловсруулалтын чанар дээшилнэ | -Мэдээллийн үнэн бодит байдал<br>-Мэдээллийн хүрэлцээтэй байдал<br>-Мэдээллийн шинэлэг, ашигтай байдал<br>-Мэдээллийн хүртээмжтэй байдал<br>-Хяналт-шинжилгээний үр дүнг боловсруулах, мэдээлэл түгээх арга технологийн түвшин | БСШУЯ<br>Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар,<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |
| Зорилт. (МД4) Мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн чанар, менежментийг хариуцдаг тогтолцоо бий болгох | | | | |
| МД4.1 | Багшлах эрх олгох, мэргэшлийн зэрэг олгох, мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагааг уялдуулах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий "Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт" байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх<br>(2010-2011 оны хичээлийн жилээс) | -Багшийн мэргэжлийн ур чадварын хөгжлийг хангах үйл ажиллагааг хариуцан зохицуулдаг албан ёсны бүтэц институтчилагдана | -Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтийн статус, бие даасан байдал<br>-Багш нарын мэргэшил дээшлүүлэх институтийн чадавхи, нэр хүнд | БСШУЯ<br>СЯ<br>ТӨХ |
| МД4.2 | Мэргэшил дээшлүүлэх үндсэн болон кредит олгох сургалтын хөтөлбөрт магадлан шинжилгээ хийж шалгаруулдаг механизм бүрдүүлэх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Мэргэжил дээшлүүлэх сургалтын чанарын төлөө шударга өрсөлдөөн бий болж, сургалтын чанарын баталгаа нэмэгдэнэ<br>-Мэргэшил дээшлүүлэх эрх бүхий байгууллагуудын хорших, түншлэх, хамтын ажиллагааны механизмууд төлөвшинө | -Сургалтын хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ хангасан байдал<br>-Сургалтын хөтөлбөрийн чанар<br>-Сургалтын хөтөлбөр боловсруулах, шалгаруулах ажлын ил тод, нээлттэй, шуурхай байдал<br>-Сургалтын хөтөлбөрийн өртөг<br>-Сургалтын хөтөлбөрийн тоо (зориулалтаар, агуулгаар, жилээр)<br>-Сургалтын хөтөлбөр шалгаруулах шийдвэр гаргахад мэргэжлийн байгууллагын төлөөллийн эзлэх хувь | БСШУЯ<br>Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, |
| МД4.3 | Мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт магадлан шинжилгээ хийх шинжээчид, сургагч багш нарыг бэлтгэх<br><br>(2010-2011 оны хичээлийн жилээс) | -Мэргэшсэн шинжээчид, сургагчид бэлтгэгдэнэ<br>-Олон байгууллагын хүмүүс мэдлэг, туршлагаа солилцох боломж нэмэгдэнэ<br>-Шинжээчид, сургагчдын хариуцлага нэмэгдэнэ | -Шинжээчид болон сургагч багш нарын онол, арга зүйн ур чадварын түвшин<br>-Мэргэшил дээшлүүлэх сургалт явуулж байсан туршлага<br>-Мэргэжлийн ёс зүй<br>-Батламж авсан хүний тоо (жилээр, мэргэжлээр) | БСШУЯ<br>Монголын багш нарын холбоо |

| | | | | |
|---|---|---|---|---|
| МД4.4 | Сургууль, цэцэрлэгийн "Заах аргын нэгдэл"-ийн бүтэц, үйл ажиллагааны арга хэлбэрийг уян хатан болгож, сургалтын хөтөлбөр боловсруулах, хичээл заах, хичээлд дүн шинжилгээ хийхэд багаар ажиллах соёлыг бий болгох (2009-2010 оны хичээлийн жилээс) | -Багш нар сургуулийнхаа болон тухайн агуулгын курс хичээл, анги бүрийн курс хичээл, нэгж хичээлийн сургалтын хөтөлбөрүүдээ хамтран боловсруулж, бие биеэсээ суралцах, улмаар сургалтын чанар дээшлэх үндсэн хөшүүрэг болно | -Багш нар багаар ажиллан боловсруулсан хичээлийн хөтөлбөрийн тоо<br>-Хамтран бэлтгэж заасан, анализ хийсэн хичээлийн тоо<br>-Заах аргын нэгдлээрээ хамтран ажиллах менежмент | Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |
| Зорилт. (МД5) Мэргэшил дээшлүүлэх сургалтын зардал, санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгох | | | | |
| МД5.1 | Мэргэшил дээшлүүлэх үндсэн сургалтын зардлыг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Төрөөс багш бүрийн ажлаа эхлэх, мэргэжлээрээ туршлагажих явцыг нь бодитой дэмжсэнээр сургалтын чанарыг хангах нэг механизмтай болно<br>-Хүний нөөцийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэх механизмтай болно<br>-Мэргэшил дээшлүүлэх үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, багш нарын ур чадвараа дээшлүүлэх тэгш боломж хангагдана | -Анхны жилийн сургалтад хамрагдсан багшийн тоо, зарцуулсан зардлын хэмжээ<br>-5 дахь жилийн сургалтад хамрагдсан багшийн тоо, зарцуулсан зардлын хэмжээ<br>-10 дахь жилийн сургалтад хамрагдсан багшийн тоо, зарцуулсан зардлын хэмжээ<br>-Хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөж<br>-Нэг багшид зарцуулах зардлын бодит өсөлт | БСШУЯ<br>СЯ |
| МД5.2 | Мэргэшил дээшлүүлэх зардлыг тусгай зүйлээр сургуулийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Мэргэшил дээшлүүлэх эрэлт хэрэгцээнд баримжаалсан хөрөнгө оруулалтын зарчим үйлчилж эхэлнэ<br>-Багш ажлын байрандаа мэргэшил дээшлүүлэх боломж нэмэгдэнэ.<br>-Мэргэшил дээшлүүлэх зардлын үр ашиг нэмэгдэнэ | -Сургуулийн жилийн төсөвт тусгасан мэргэшил дээшлүүлэх зардлын хэмжээ (сургууль бүрээр)<br>-Сургуулийн жилийн төсөвт тусгасан мэргэшил дээшлүүлэх зардлын санхүүжилтийн гүйцэтгэл (сургууль бүрээр)<br>-Сургуулийн мэргэшил дээшлүүлэх зардлаар явуулсан сургалтын тайлан | БСШУЯ<br>СЯ<br>Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, |
| МД5.3 | Мэргэшил дээшлүүлэх кредит олгох болон бусад төрөлжсөн сургалт, хэрвээ сургалтыг эрэлтэд суурилсан санхүүжилттэй болгох<br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагаанд сургалтын төлбөр, хандив, тусламж, төсөл хөтөлбөрийн зэрэг олон эх үүсвэрүүдийг ашиглах боломжтой болно | -Үйлчлүүлэгчдийн хэрэгцээ хангасан байдал<br>-Нийт зардалд эх үүсвэр бүрийн эзлэх хувь (жилээр) | БСШУЯ<br>СЯ |
| Зорилт. (МД6) Багш нарын зорилтот бүлэг бүрт зориулан боловсролын шинэчлэлийн хэрэгжилтийг дэмжсэн сургалт зохион байгуулах | | | | |
| МД6.1 | Мэргэшил дээшлүүлэх сургалтын үндэсний болон орон нутгийн түвшний дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж мөрдөх<br><br>(2009-2010 оны хичээлийн жилээс) | -Бүх мэргэжлийн багш, удирдах болон мэргэжлийн ажилтнуудын хамрагдах сургалтын агуулга, хугацаа, давтамж, сургагч багшийн болон санхүүгийн нөөцийн төлөвлөлттэй болно | -Сургалтын төрөл (зорилго, хамрах хүрээгээр, зохион байгуулалтын хэлбэрээр)<br>-Зорилтот бүлгийн нэр<br>-Сургалтын агуулга<br>-Нэг сургууль, багшид ирэх ачаалал, давтамж<br>-Зардлын хэмжээ (жилээр, сургалт бүрээр, нийт дүнгээр) | БСШУЯ<br>Багш бэлтгэдэг сургууль,<br>Боловсролын хүрээлэн,<br>Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| МД6.2 | Багш, удирдах болон мэргэжлийн ажилтны мэргэшил дээшлүүлэх сургалтын модулийн тогтолцоо боловсруулж, магадлан шинжилгээ хийж бүртгэх (2009-2010 оны хичээлийн жилээс) | -Сургалтын хөтөлбөрийн чанар дээшилснээр сургалтын үр өгөөж нэмэгдэнэ -Багш, ажилтны ур чадварт бодитой ахиц гарах үндсэн нөхцөл бүрдэнэ | | БСШУЯ Багш бэлтгэдэг сургууль, Боловсролын хүрээлэн, Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар |
| МД6.3 | Мэргэшил дээшлүүлэх, үндсэн, төрөлжсөн, хөрвөх, бие даах сургалт зохион байгуулах (2009-2010 оны хичээлийн жилээс) | -Ур чадвараа хөгжүүлэх цуврал сургалтад багш бүр хамрагдсан байна -Багш нэг бүрийн мэргэшил, арга зүйд бодитой ахиц гарна -Сурагчдын боловсролын чанарт бодит ахиц гарна | -Мэргэшил дээшлүүлсэн хүний тоо (жилээр, агуулгаар, зорилтот бүлэг бүрээр) -Мэргэшил дээшлүүлэх зардлын хэмжээ (жилээр, эх үүсвэрээр) -Нэг багшийн сургалтад хамрагдсан давтамж (жилээр, хөтөлбөрийн хугацаанд) | БСШУЯ Багш бэлтгэдэг сургууль, Боловсролын хүрээлэн, Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг |
| МД6.4 | Гадаад оронд багш нарыг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулж, дэвшилтэт туршлага, арга зүйг судлах, нэвтрүүлэх (2009-2010 оны хичээлийн жилээс) | -Багшийн мэргэшил, арга зүйн хөгжлийг олон улсын жишигт ойртуулна | -Сургалтад хамрагдсан хүний тоо (жилээр, агуулгаар, зорилтот бүлгээр) -Мэргэшил дээшлүүлсэн улсын тоо, нэр (жилээр, агуулгаар) -Сургалтад зарцуулсан зардлын хэмжээ (жилээр, сургалт бүрээр, эх үүсвэрээр) | БСШУЯ Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр** | **Дугаар 338** | **Улаанбаатар хот**

**Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай**

Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 12.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрын дарга Дашдоржийн Мандахад Улсын ерөнхий байцаагчийн эрх олгосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай" Засгийн газрын 2005 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 164 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД М.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.**
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 265958
Индекс 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 3